

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ӨГӨХ

**АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГЫГ 1,921.0 САЯ ТӨГРӨГӨӨР
НЭМЭГДҮҮЛЖ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ 5,157.7 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ
БОЛОМЖТОЙ БАЙНА.**

Аудитын код: ОРА-2025/07-13-ШТА-НА

Цахим хуудас: www.audit.mn	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70350757 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn Аудитор: Ц.Одгэрэл Утас: 70350757 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn
Эрдэнэт хот 2025 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 28 өдөр


Дугаар А/23

Баян-Өндөр сум

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсүгэй.
3. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Зоригтбаяр/-д зөвлөсүгэй.
4. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2026 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор В.Жавзмаа, Г.Оргилмөрөн нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  П.ПҮРЭВЛХАГВА



D:\my doc \bichig hereg\ tushaal \ 2025.doc

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	3
Дүрслэлийн товъёг.....	3
Ерөнхий мэдээлэл.....	5
НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН БОЛОН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.	8
1.1 Орхон аймгийн 2026 оны төсвийн төсөл нь дунд хугацааны бодлогын баримтын бичгүүдтэй 95.4 хувь нийцсэн байна.	8
1.2 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.	10
ХОЁР. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТООЦООЛООГҮЙ БАЙНА.	11
2.1 Аймгийн 2026 оны төсвийн татварын орлогыг 605.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,316.0 сая төгрөгөөр нийт 1,921.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.	11
2.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны төсвийн төсөл 4,081.1 сая төгрөгийн зардлаас 1,255.0 сая төгрөгийн 5 арга хэмжээг бууруулах саналтай байна.	13
ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.	15
3.1.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 14 ТАХ-г тусгасан байна.	15
3.2.Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөсөөр байна.	19
ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 50.0 ХУВЬТАЙ БАЙНА.	20
ДҮГНЭЛТ:.....	21
ЗӨВЛӨМЖ:.....	21
ХАВСРАЛТ:.....	22

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЦҮЗГ	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
ЭБЦТС ТӨХК	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2026 онд төлөвлөсөн ТАХ	8
Хүснэгт 2	Алсын хараа-2050	9
Хүснэгт 3	Орон нутгийн орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт 4	Торгуулийн орлогын харьцаа ба хувь	11
Хүснэгт 5	Төсөвт байгууллагын өөрийн орлогын үзүүлэлт	12
Хүснэгт 6	Зардлын харьцаа ба хувь	13
Хүснэгт 7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт	14
Хүснэгт 8	Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024- 2025 оны төсвийн гүйцэтгэл хэтрэлт хэмнэлт	14-15
Хүснэгт 9	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	9

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны А/107 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Орхон аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн Орхон аймгийн 2026 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргалаа.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсвийн төсөл нь тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн, Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах нөөц боломж байгаа эсэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг арвилан хэмнэлттэй байдлаар, санхүүжилтийн үр ашгийг харгалзан, оновчтой төлөвлөсөн эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв, Орхон аймгийн 2024, 2025 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, 2026 оны төсвийн төсөл, танилцуулга, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллагуудаас ирүүлсэн судалгаа болон холбогдох бусад баримт материалд үндэслэн гүйцэтгэв.

Аудитад Орхон аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд цуглуулсан төсөвт байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт зэргийг ашиглав.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхагва хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, Г.Оргилмөрөн, аудитор Б.Азжаргал, Л.Болормаа, А.Лхагвагэрэл, О.Гантуяа, Г.Даваасүрэн, Ц.Одгэрэл, Ж.Наранчимэг

**Аудитын явцад
учирсан хүндрэл,
бэрхшээлүүд:**

нар 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 2023 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Эцэслэсэн боловсруулсан төсвийн төслийг хүлээн авснаас хойш 7 хоногт гүйцэтгэсэн болон аудитад ирүүлсэн төсвийн төсөл иж бүрэн бус байсан зэрэг нь аудитын цар хүрээг хязгаарлах нөхцөл болж байна.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн танилцуулгад Монгол Улсын Засгийн газраас бодлогын 3 зорилт, 9 чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

Бодлогын 3 зорилт:

1. Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд 5-6 хувьд хадгалж макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.
 - Түүхий эдийн үнийн савлагаанаас шалтгаалан төсвийн орлого хязгаарлагдмал байгаа энэ үед хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад бонд, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр эдийн засгийг дэмжинэ.
 - Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрчимжүүлж, бүтээмж болон хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ уул уурхайн бус салбарын экспортын бүтэц, өрсөлдөх чадвар, зах зээлийн хүрээг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлнэ.
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламжийн санхүүжилтийг бодлогын тэргүүлэх салбар болох хүний хөгжил буюу боловсрол, эрүүл мэнд, мөн хувийн хэвшлийн бизнесийн орчныг сайжруулах суурь дэд бүтэц, түүн дотроо эрчим хүчний салбарт нэн тэргүүний төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.
2. Төсвийн урсгал зардлыг 2025 оны түвшинд буюу ДНБ-ий 24 хувьд хязгаарлаж, Иргэн төвтэй-Хүний хөгжлийг дэмжсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
 - Нийгмийн суурь үйлчилгээ болох эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - Эмзэг бүлгийн орлогын баталгааг сайжруулах, хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн оновчтой зохицуулалт бүхий хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжинэ.
 - Төсвөөс санхүүжүүлдэг зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулна.
 - Иргэдийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх татварын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.

- Бизнес дэх төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшилд бизнес, хөрөнгө оруулалтын шинэ орон зай, боломжийг нээж өгнө.

Бодлогын 9 чиглэл:

1. Эдийн засгийг идэвхжүүлэх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлнэ.
 - Орлого төвлөрүүлдэг аймаг, нийслэл гадаад, дотоодын зах зээлээс бонд босгож эрчим хүч, дэд бүтэц зэрэг тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
 - Орон сууцны төрөлжсөн банк байгуулж, зээлийн хүртээмжийг сайжруулах замаар барилга, үл хөдлөх салбарын үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг дэмжинэ.
 - Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хялбаршуулж, төр шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
2. Эдийн засаг болон экспортын төрөлжилтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
 - Нэмүү өртөг шингэсэн уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.
 - “Go Mongolia” арга хэмжээг үргэлжлүүлж, аялал жуулчлалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар орлогыг нэмэгдүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
3. Эдийн засгийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, худалдаа, логистикийн чадавхыг өргөжүүлснээр эдийн засгийн өсөлтийн суурийг бэхжүүлнэ.
 - Эрчим хүчний салбарт: Хөрөнгө оруулалтын чиглэлээр нийт эх үүсвэрийн хүрээнд эрчим хүчний салбарт 3.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэнэ.
 - Зам тээврийн салбарт: Хөрөнгө оруулалтын чиглэлээр нийт 1.2 их наяд төгрөгийг санхүүжилт хийгдэх бөгөөд ингэснээр 551.3 км авто зам, 299.9 метр урт гүүр байнгын ашиглалтад орно.
 - Харилцаа холбоо: Кибер аюулгүй байдлыг хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, хөгжлийн индексийг дээшлүүлж, нийгмийн тэгш байдлыг дэмжиж, төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.
 - Инженерийн дэд бүтэц: Хотын хүртээмжтэй байдал, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, өндөр чанартай болгох, иргэдийн аюулгүй байдал, амьдралын таатай орчныг бүрдүүлэх, түгжрэлийг бууруулах.
 - Онцгой байдал: Дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
4. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
 - Эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой механизм болгоход чиглүүлж шинэчилнэ.
 - Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулах, тусламж үйлчилгээг найдвартай хүргэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна.
 - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, үдийн цай, дотуур байрын зардлыг боловсролд хамрагдах хүүхдийн тооны өсөлттэй уялдуулж нэмэгдүүлнэ.

- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал хариуцагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор 2026 онд хоолны зардлын 50 хувийг эцэг эх хариуцдаг болно.
 - Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах, олон улсын түвшинд нийцүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори байгуулах, хоол үйлдвэрлэл, номын сан, урлагийн заалыг тохижуулах, дуу хөгжмийн хичээлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээлийн хэрэглэгдэхүүн, сургуулиудын биеийн тамирын техник хэрэгсэл, цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг хангах, боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулна.
5. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүртээмжийг сайжруулна.
 6. Орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ.
 - Орон сууцны санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн банк байгуулна.
 7. Төсвөөс санхүүжүүлдэг зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулна.
 - Төрийн байгууллагын туслах үйл ажиллагаа (цэвэрлэгээ, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ, халаалт г.м), тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, жижиг дунд үйлдвэрлэлийг болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа, ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, мэргэжлийн боловсрол сургалтын чиг үүргийг хувийн хэвشلээр гүйцэтгүүлэх
 8. Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг зохистой хэмжээнд шаталсан хэлбэрээр бууруулах, татварын тогтолцоо, бүртгэл, хамрагдалтыг сайжруулах, бүх нийтээр жигд шударга төлдөг татварын орчин бүрдүүлэх, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих татварын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.
 9. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, бүтцийн өөрчлөлт хийнэ.
 - Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд санал болгож, бүтцийн өөрчлөлт хийнэ.
 - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, түүний цалин хөлсний бодлогыг оновчтой тогтоож, удирдлагын багийг улс төрөөс ангид, нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулан томилно.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд Орхон аймгийн төсвөөс 92,550.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 30,640.9 сая төгрөгөөр тооцож тусгасан байна.

Сангийн яамнаас Орхон аймгийн суурь орлогыг 218,210.0 сая төгрөгөөр, суурь зарлагыг 73,917.1 сая төгрөгөөр, үндсэн тэнцлийн ашгийг 144,292.9 сая төгрөгөөр, Төсвийн тухай хуулийн 56.2.1¹-д заасны дагуу 51,742.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт үлдээхээр хянасан байна.

¹ 56.2.1-д “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасан.

НЭГ. ОРХОН АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН БОЛОН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

1.1 Орхон аймгийн 2026 оны төсвийн төсөл нь дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй 95.4 хувь нийцсэн байна.

Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/15 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-г баталсан байна.

Уг хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг үндэслэжээ.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардалд 323,276.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 202 ТАХ, төсөл хөтөлбөрийн 18,978.6 сая төгрөгийн 162 ТАХ, авто замын сангийн 3,092.4 сая төгрөгийн 4 ТАХ, Байгаль хамгаалах сангийн 4,761.9 сая төгрөгийн 32 ТАХ, Орон нутгийн хөгжлийн сангийн 33,109.4 сая төгрөгийн 37 ТАХ, нийт 361,239.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 437 ТАХ-г 223,267.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 1. 2026 онд төлөвлөсөн ТАХ

Төсөл арга хэмжээний төрөл		ТАХ тоо	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
Шинэ	Барилга байгууламж	51	158,352.35	81,933.66
	Болзошгүй аваарын зардал	1	3,619.90	3,619.90
	Зөвлөх үйлчилгээ	4	3,851.00	3,851.00
	Их засвар	68	43,808.26	43,808.26
	Тоног төхөөрөмж	49	12,739.97	12,739.97
	Цахим систем	3	6,079.00	6,079.00
	Төсөл хөтөлбөр	176	19,188.22	19,188.22
	Дүн	352	247,638.70	171,220.01
Шилжих	Барилга байгууламж	83	109,832.55	48,278.63
	Зөвлөх үйлчилгээ	1	3,228.47	3,228.47
	Тоног төхөөрөмж	1	540.00	540.00
	Дүн	85	113,601.01	52,047.10
Нийт дүн		437	361,239.71	223,267.10

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого” нь суурь 9 зорилго, 47 зорилттой бөгөөд зорилгын хэрэгжилтийг үнэлэх 73 шалгуур үзүүлэлттэй байна.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудтай орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан шинээр хэрэгжүүлэх 252,277.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 353 ТАХ-г тулгахад бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.


Хүснэгт 2. Алсын хараа-2050

№	Зорилт	TAX тоо	Төсөвт өртөг	Эзлэх хувийн жин
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	3,551.4	4.5%
2	Хүний хөгжил	168	203,979.5	47.5%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	36	11,334.1	10.1%
4	Эдийн засаг	13	869.7	3.6%
5	Сайн Засаглал	47	17,926.1	13.4%
6	Ногоон хөгжил	23	2,981.0	6.5%
7	Амар тайван аюулгүй байдал	33	6,959.1	9.9%
8	Бүсчилсэн хөгжил	16	4,502.6	4.5%
Нийт		353	252,277.8	100.0%


Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх 252,277.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 175,859.1 сая төгрөгөөр санхүүжих дүнтэй 353 TAX-г “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4 зорилтын 19 үйл ажиллагааны 152 арга хэмжээтэй баталгаажуулалт хийхэд 94.9 хувь буюу 335 TAX нийцсэн байна.

Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн TAX-ны 24.4 хувь нь “Хүний хөгжил”, 44.8 хувь нь “Эдийн засгийн бодлого”, 25.8 хувь нь “Хүний эрхэнд суурилсан засаглал” зорилтын арга хэмжээнүүд байна. Харин “Хойд бүсийн хөгжилд орон нутгийн оролцоо” зорилтод TAX төлөвлөөгүй байна.

Дүрслэл 1. Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр



Орхон аймгийн ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 03/46 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд 4 зорилтын хүрээнд 188 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.



2026 онд шинээр хэрэгжүүлэх 353 TAX нь “Орхон аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-тэй 92.1 хувь буюу 242,916.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 325 TAX нийцэж байгаа боловч 7.9 хувь буюу 9,901.4 сая төгрөгийн 28 TAX нийцэхгүй байна. “Бүсчилсэн хөгжлийн бодлого” зорилтод төлөвлөгдсөн 4 арга хэмжээнд TAX төлөвлөөгүй байна.

1.2 Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан ТАХ-г аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын саналд үндэслэн ач холбогдлоор нь эрэмбэлсэн боловч Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.², 2.2.2³-д заасны дагуу эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийг хэрхэн тодорхойлсон талаар нотлох баримт хангалтгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын шилжих үлдэгдэл болон шинээр хийгдэх хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, цаашид төсвөөс гарах урсгал зардлын тооцоо судалгаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4⁴, 29.1⁵, 29.2⁶-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- Хот тохижуулах газарт нийтийн тээврийн авто гарааш барих 3,501.0 сая төгрөг,
- Их Залуу баг. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих ажил 2,800.0 сая төгрөг,
- Том оврын авто машины нэгдсэн зогсоол хийх ажил 3,100.0 сая төгрөг,
- Говил баг. Хамгаалалтын хашаа, гэрэлтүүлэг хийх ажил 547.3 сая төгрөг тус тус байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан боловч өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй болон төрийн өмчит байгууллагад 447.2 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашигт байдлыг алдагдуулжээ. Тухайлбал:

- Эрдэнэт-Ус ОНӨХК-ний хурлын зааланд дэлгэц худалдан авах 55.2 сая төгрөг,
- Мэдээлэл холбооны сүлжээний байранд хэсэгчилсэн засвар хийх ажил 140.0 сая төгрөг,
- Мэдээлэл холбооны сүлжээний байрны гадна зогсоол хийх ажил 151.9 сая төгрөг,
- “ЭБЦТС ТӨХК”-нд дэмжлэг үзүүлэх 100.0 сая төгрөг байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн зардалд төлөвлөсөн 18,978.6 сая төгрөгийн 162 ТАХ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 209.6 сая төгрөгийн 13 ТАХ, ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх 3,000.0 сая төгрөгийн 1 ТАХ, нийт 19,188.2 сая төгрөгийн 176 ТАХ-г иргэдэд хэрхэн ач тусаа өгснийг үнэлж дүгнээгүй, үр ашгийг тооцолгүй төсөвт төлөвлөсөөр байна.

Мөн түүнчлэн зарим төлөвлөсөн ТАХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5⁷, 15.2.7⁸-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- Эрин зууны бахархал “Эрдэнэт хот” уран зураг худалдан авах 120.0 сая төгрөг,
- ТЦҮЗГ-аас жилийн турш үе шаттайгаар олон талт сургалт зохион байгуулах үйл ажиллагааны зардал 20.0 сая төгрөг,

² 2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

³ 2.2.2. Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

⁴ 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ 29.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бэлтгэнэ.

⁶ 29.2. Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁷ 15.1.5. төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

⁸ 15.2.7. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.

- Нийт төрийн байгууллагууд, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын албан хаагчдыг хамруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулах 25.0 сая төгрөг,
- Гэр бүлийн хөгжлийн төвийн сургалт, нөлөөллийн зардал 50.0 сая төгрөг,
- Төрийн байгууллагын мэдээлэл, харилцааг өргөжүүлэх, сургалт зохион байгуулах, судалгаа авахад шаардагдах зардал 80.0 сая төгрөг,
- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн сургалт зохион байгуулах ажлын зардал 20.0 сая төгрөг байна.

ХОЁР.АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТООЦООЛООГҮЙ БАЙНА.

2.1 Аймгийн 2026 оны төсвийн татварын орлогыг 605.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,316.0 сая төгрөгөөр нийт 1,921.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Орон нутгийн төсвийн орлого 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 335,267.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 221,388.6 сая төгрөг төвлөрч гүйцэтгэл 60.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Орон нутгийн орлогын гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын нэр төрөл		Гүйцэтгэлээр		Төлөвлөгөө
		2024	2025.10 сар	2026
Татварын орлого	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,389.0	1,945.8	1,600.0
	Улсын тэмдэгтийн хураамж	984.4	654.0	600.0
Татварын бус орлого	Хүү, торгуулийн орлого	2,201.0	2,435.3	2,100.0
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	53.9	40.4	28.0
	Түрээсийн орлого	945.3	560.2	606.1
	Орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлого	2,192.7	3,479.0	3,700.0

- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 2025 оны 10 дугаар сарын байдлаар 1,945.8 сая төгрөг, хүлээгдэж байгаа гүйцэтгэл 2,335.0 сая төгрөгөөр тооцоолж, мөн авто машины тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалан 2026 оны орлогыг 2,000.0 сая төгрөг буюу 400.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- Улсын тэмдэгтийн хураамж 2024 онд 984.4 сая төгрөг, 2025 оны 10 сарын дүнгээр 654.0 сая төгрөг буюу 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл 784.8 сая төгрөгөөр тооцоолж 2026 оны төсвийг 780.0 сая төгрөг буюу 180.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Аймаг, сумын торгуулийн орлогын гүйцэтгэлийг 2023-2025 оноор харуулбал:

Хүснэгт 4. Торгуулийн орлогын харьцаа ба хувь

/сая. төгрөг/

№	Сумын нэр	2023 он			2024 он			2025 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт
1	Баян-Өндөр	0	0	0	0	0	0	0	0	0
2	Жаргалант	40.0	58.0	-18.0	100	102.1	-2.1	120.0	104.7	15.3
3	Аймаг	1,450.0	2,032.5	-582.5	1,850.0	2,201.0	-351.0	1,850.0	2,435.3	-585.3
Нийт дүн		1,490.0	2,090.5	-600.5	1,950.0	2,303.1	-353.1	1,970.0	2,540.0	-570

Дээрх хүснэгтээс харахад торгуулийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 2023 онд 582.5 сая төгрөг, 2024 онд 351.0 сая төгрөг, 2025 оны 10 сарын гүйцэтгэлээр 585.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг 2,922.4 сая төгрөгөөр тооцоолж 2026 оны төсвийг 2,900.0 сая төгрөг буюу 800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2026 оны төсвийн саналд 28.0 сая төгрөгөөр тооцоолсон байна.

Хүснэгт 5. Төсөвт байгууллагын өөрийн орлогын үзүүлэлт

/сая.төгрөг/

№	Он	АЗДТГ	Орхон аймгийн сум дундын ойн анги	Худалдан авах ажиллагааны газар	Нийт
1	2024 он	9.1	10.60	34.7	53.9
2	2025 оны 06 сар	8.2	1.7	30.5	40.4

Дээрх хүснэгтээс харвал орлого төвлөрүүлдэг байгууллагуудын 2024 оны өөрийн орлого 53.9 сая төгрөг, 2025 оны хагас жилийн байдлаар 40.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнээс харахад 2026 оны төсвийг 40.4 сая төгрөг буюу 12.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- Түрээсийн орлого 2024 оны гүйцэтгэл 945.0 сая төгрөг, 2025 оны 10 сарын гүйцэтгэлээр 560.2 сая төгрөг, 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг 672.2 сая төгрөгөөр тооцоолж 2026 оны төсвийг 670.0 сая төгрөг буюу 64.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

- Орон нутгийн өмчийн эд хөрөнгө борлуулсны орлогыг 2026 оны төсөвт зөвхөн Орлогод нийцсэн орон сууцыг худалдан борлуулах тооцоог тусгасан байна. Орон нутгийн өмчид бүртгэлтэй 443.7 сая төгрөгийн доод үнийн саналтай 5 үл хөдлөх хөрөнгийг 2026 онд дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэртэй хөрөнгийн орлогыг тооцоолоогүй байна. Иймд 2026 оны төсвийг 4,140.0 сая төгрөг буюу 440.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 50.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. /Жаргалант сум 0 төгрөгөөр, Баян-Өндөр сум 50.0 сая төгрөг/

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг Баян-Өндөр сум багадаа 10.0 сая төгрөгөөр, Жаргалант сум 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

Баян-Өндөр сум: Аймгийн Засаг даргын 2024.06.11-ны А/427 дугаар захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон Баян-Өндөр сумын нутагт байрлах “Хуурайн ам” нэртэй газрын 81.9 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын MV-61000020 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийг холбогдох мэргэжилтнүүдийн өсгөн мэдээллээр ирэх онд 80 мянган куб.метр бүтээгдэхүүн олборлон борлуулахаар төлөвлөснийг Засгийн газрын 2025 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 5.2⁹-д заасан тарифыг жишиг үнэлгээ болгож тооцвол борлуулалтын орлого 400.0 сая төгрөгийн 2.5 хувь нь 10.0 сая төгрөг болж байна.

Жаргалант сум: Тус суманд тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг компани нь хэсэг хугацаанд үйл ажиллагаагаа түр зогсоож байгаад 2025 оноос эргэн үйл ажиллагаагаа явуулж 2025 онд 1 сая ширхэг тоосго үйлдвэрлэсэн талаар мэдээлэл ирүүлснийг нэг ширхэг тоосгоны үнийг багадаа 600 төгрөгөөр тооцвол борлуулалтын орлого 600.0 сая төгрөгийн 2.5 хувь нь 15.0 сая төгрөг болж байна.

⁹ Засгийн газрын 2025 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 5.2-д “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр барих болон тусгай зориулалтын авто зам барихад ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нэг шоо метр тутамд 5000 төгрөгөөс хэтрэхгүй байна”.

2.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны төсвийн төсөл 4,081.1 сая төгрөгийн зардлаас 1,255.0 сая төгрөгийн 5 арга хэмжээг бууруулах боломжтой байна.

Аймгийн 2025 оны төсвийн 92,550.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, 2,713.1 сая төгрөгийг дамжуулан зээлийн эргэн төлөлт, 36,088.1 сая төгрөгийг төрийн байгууллагын урсгал санхүүжилт, 8,456.6 сая төгрөгийг сумдад олгох санхүүгийн дэмжлэг, 227,906.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, 19,580.5 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 8,276.7 сая төгрөгийг орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээ ашиглалтын зардалд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн зардлыг өмнөх оны төсвийн төсөлтэй харьцуулж харуулбал.

Хүснэгт 6. Зардлын харьцаа ба хувь

				/сая.төгрөг/	
№	Зардлын ангилал	2025	2026	Өсөлт, бууралт	Хувь
1	Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилт	36,592.70	36,088.10	-504.6	-1.3
2	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	8,456.70	8,456.70	0.0	0.0
4	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	121,662.20	202,536.40	80,874.20	66.4
5	Аймгийн ОНХС	55,565.60	17,619.20	-37,946.40	-68.2
6	Авто замын сан	2,216.00	3,092.30	876.30	39.5
7	Байгаль хамгаалах төсөл арга хэмжээ	4,622.00	4,658.10	36.10	0.78
8	Баян-Өндөр сум ОНХС	12,238.70	10,280.30	-1,958.40	-16.0
9	Жаргалант сум ОНХС	11,042.10	9,300.10	-1,742.00	-15.7
10	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт зардал	8,057.50	8,276.70	219.20	2.7
11	Улсын төсөвт төвлөрүүлэх	145,266.80	92,550.80	-52,716.00	-36.2
12	Дамжуулан зээлийн эргэн төлөлт	2,755.60	2,713.10	-42.50	-1.5
Нийт дүн		408,475.90	395,571.80	(12,904.10)	-3.2

Хүснэгтээс харахад нийт зардал -12,904.1 сая төгрөгөөр буюу -3.2 хувиар буурсан байна. Тухайлбал: Аймгийн ОНХС-ийн зарцуулалт өмнөх оноос -37,946.4 сая төгрөгөөр буюу -68.2 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх орлого -52,716.0 сая төгрөгөөр буюу -36.2 хувиар, орон нутгийн төрийн байгууллагын санхүүжилт -504.6 сая төгрөгөөр буюу -1.3 хувиар, сумдын ОНХС-ийн зарцуулалт 3,700.4 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны төсвийн төсөлд Төрийн нэрийн өмнөөс хөтөлбөр арга хэмжээний Бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд “Намын бүлгүүдэд” нэртэй 820.0 сая төгрөгийн дэмжлэгийн чанартай зардлыг төсөвлөсөн байна. Энэ зардал нь Улс төрийн намын тухай хуулийн 10.1.5¹⁰, 34.6¹¹, 34.6.3¹² гэснийг зөрчсөн байна.

Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардал ангилалд “Бусад” нэртэй арга хэмжээнд 159.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

¹⁰ Улс төрийн намын тухай хуулийн 10.1.5.”энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”

¹¹ Улс төрийн намын тухай хуулийн 34.6-д “Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно:”

¹² Улс төрийн намын тухай хуулийн 34.6.3-д “төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага;”

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг" гэдгийг хангахгүй байна. Мөн дээрх зардлын ангилалд "Аймгийн статистикийн хэлтэст" нэртэй арга хэмжээнд 11.0 сая төгрөг, "Ази, дэлхийн аваргын тэмцээнд оролцох тамирчдад" нэртэй арга хэмжээнд 65.0 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна. Энэ нь аймгийн Хөрөнгө оруулалтын зардлын төсөл хөтөлбөрт багтсан зардалтай давхацсан байна. Үүнээс дүгнэхэд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардал 235.0 сая төгрөгийн зардал бууруулах боломжтой байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2026 оны төсөв 800.0 сая төгрөг буюу өмнөх оноос 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцоолсон байна.

Хүснэгт 7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт /сая төгрөг/

Арга хэмжээ	2024 он			2025 он			
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл 10 сар	ХБ гүйцэтгэл	Өсөлт, бууралт
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	600.0	440.7	159.3	600.0	358.5	430.2	169.9

Дээрх хүснэгтээс 2024 оны гүйцэтгэл 73.5 хувийн хэрэгжилттэй, 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл 71.6 хувийн хэрэгжилттэй байна. Мөн аймгийн Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр зардалд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээнд 40.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 800.0 сая болгон 200.0 төгрөгөөр нэмж өөрчлөхөд нөлөөлсөн хүчин зүйл, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах зардлын тооцоо, хүрэх үр дүнг тодорхойлоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.5¹³ гэснийг хангаагүй байна.

Өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, нэмсэн зардлын хэрэгцээ шаардлага зэргээс дүгнэхэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг 200.0 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.

Аймгийн ЗДТГ-ын 2026 оны төсвийн төсөлд 5 арга хэмжээний 3.902,7 сая төгрөгийг бууруулах

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд аймгийн Засаг даргын тамгын газрын зарцуулах нийт төсвийг 12,026.7 сая төгрөгөөр буюу өмнөх оноос 4,002.2 сая төгрөгөөр, Засаг даргын нөөц сангийн төсвийг 3,564.5 сая төгрөг буюу өмнөх оноос 2,530.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 он, 2025 онуудын төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилт жил бүр зарцуулаагүй үлдэгдэл өндөртэй тайлагнадаг байна.

Хүснэгт 8. Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024- 2025 оны төсвийн гүйцэтгэл хэтрэлт хэмнэлт /сая.төгрөг/

Үзүүлэлт	2024 он			2025 он			
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл 10 сар	ХБ гүйцэтгэл	Өсөлт, бууралт

¹³ 4.1.5-д "төсөв" гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;"

АЗДТГ	5,511.6	4,584.4	960.4	7,000.0	4,858.4	5,830.1	1,159.0
ЗДНөөц сан	650.0	323.6	296.4	1,034.5	696.0	835.2	199.3
Нийт	6,161.6	4,908.0	1,256.8	8,024.5	5,554.4	6,665.3	1,359.2

Дээрх хүснэгтээс харахад аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 онд төсвийн хэрэгжилт 79.6 хувь буюу 1,256.8 сая төгрөг, 2025 онд төсвийн хэрэгжилт 83.1 хувь буюу 1,359.2 сая төгрөгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Засаг даргын нөөц сангийн зарцуулалт 2024 онд 54 хувийн хэрэгжилттэй, 2025 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 81 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь байгууллагын төсвийн шаардагдах санхүүгийн тооцооллыг бодитой хийдэггүй, санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, хүрэх үр дүнг тооцоолдоггүйтэй холбоотой байна. Мөн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийг холбогдох журмын дагуу зарцуулж байх гэсэн зөвлөмжийг хүргүүлж байсан.

Эрдэнэт хотын 50 жилийн баяр наадмыг 2026 онд тэмдэглэхтэй холбоотой нэмсэн боловч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах төсөв, хүрэх үр дүнг тооцоолоогүй доорх зардлуудыг тусгасан байна.

- Засаг даргын нөөц сангийн зардал 3,564.5 сая төгрөг
- Эрдэнэт хотын түүхт ойг угтан ирсэн зочдыг хүлээн авах зардал 400.0 сая төгрөг
- Төсөл хөтөлбөрийн зардалд 650.0 сая төгрөг зэрэг зардлууд багтсан байна.

Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал зардалд албан хаагчдад орон сууц худалдан авах, (анх удаа) амины орон сууц барих зэрэгт дэмжлэг үзүүлэх зардалд 300,0 сая төгрөг төсөвлөсөн нь хэт өндөр дүнтэй, үрэлгэн, тооцоо судалгаагүй байна.

Бусад албан хаагчдын нормын хувцас, хэрэгсэл зардалд 22.7 сая төгрөг төсөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна.

Өмнөх онуудын төсвийн гүйцэтгэл, нэмсэн зардлын хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах төсөв, хүрэх үр дүнг тооцоолоогүй зэргээс дүгнэхэд аймгийн Засаг даргын тамгын газрын 2026 оны төсвийг 3.902,7 сая төгрөгөөр бууруулах саналтай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан байтал өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй байгууллага Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-д 55.2 сая төгрөгийн хөрөнгө төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашигт байдлыг алдагдуулж байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.

3.1.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 14 ТАХ-г тусгасан байна.

Орхон аймгийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 323, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 42, нийт 323,276.1 сая төгрөгийн өртөгтэй 364 ТАХ-г 197,897.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө

/сая.төгрөг/

№	ТАХ төрөл	Шилжих ТАХ			Шинэ ТАХ			Нийт ТАХ		
		тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Барилга байгууламж	40	78,140.6	29,180.6	43	156,898.1	80,479.4	83	234,418.7	108,040.1
2	Их засвар				68	43,808.3	43,808.3	68	49,067.3	49,067.3
3	Тоног төхөөрөмж	1	540.0	540.0	45	12,553.0	12,553.0	46	13,093.0	13,093.0
4	Зөвлөх үйлчилгээ	1	3,228.5	3,228.5	1	3,050.0	3,050.0	2	6,278.5	6,278.4
5	Цахим систем	-	-	-	3	6,079.0	6,079.0	3	6,079.0	6,079.0
6	Төсөл, хөтөлбөр	-	-	-	162	18,978.6	18,978.6	162	18,978.6	18,978.6
	Нийт	42	81,909.1	32,949.1	322	241,367.0	164,948.3	364	323,276.1	197,897.4

Эх сурвалж: Орхон аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөл

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтад 2026 онд төлөвлөсөн 197,897.4 сая төгрөгийн санхүүжилтийн 16.6 хувийг шилжих, 83.4 хувийг шинээр эхлүүлэх ТАХ-нд зарцуулахаар тусгажээ.

Нийт санхүүжилтийн хэмжээг 2025 онтой харьцуулахад 10,337.8 сая төгрөг буюу 5.5 хувиар нэмэгдэж, 55.4 хувийг барилга байгууламж, 22.1 хувийг их засвар, 6.6 хувийг тоног төхөөрөмж, 3.2 хувийг зөвлөх үйлчилгээ, 3.1 хувийг цахим систем, 9.6 хувийг төсөл, хөтөлбөрийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь тоног төхөөрөмж, цахим систем, төсөл, хөтөлбөрийн зардлын санхүүжилт нэмэгдсэнээс шалтгаалан өссөн байна.

Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2025 онд дуусаж байгаа ба 2026-2030 онд баримтлах таван жилийн үндсэн чиглэлийг батлаагүй, хэлэлцүүлэх үе шатанд байгаа тул аймгийн төсвийн 2026 оны төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Орон нутгийн төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, төсөл хөтөлбөрийн судалгаа, саналыг хэдэн байгууллага, иргэнээс хүлээн авч, барилга байгууламж, үндсэн хөрөнгийн насжилт, ашиглалтын судалгаа хийгээгүй, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж буй талаар мэдээллийн сан үүсгэдэггүй байна.

Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх 353 төсөл, арга хэмжээнээс 51 нь барилга байгууламж, 68 нь их засварын ангилалд хамаарч байна. Дээрх ангилалд хамааруулсан төсөл, арга хэмжээг авч үзвэл 37 ТАХ нь барилга байгууламж, 82 нь их засварын ажилд хамаарахаар байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 4.1.1¹⁴-д заасантай нийцэхгүй байна.

Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, төсөлтэй хэрэгжих 119 ТАХ-ээс 87.4 хувь буюу 104 ТАХ нь зураг, төсөвтэй, 12.5 хувь буюу 15 нь зураг төсөв, төсөлгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29^{1.2.2}¹⁵, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

¹⁴ Барилгын тухай хуулийн 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг”,

¹⁵ Төсвийн тухай хуулийн 29^{1.2.2}-д “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”,

санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2¹⁶-д "Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх" гэж заасантай нийцээгүй ба эдгээр ТАХ-г төсвийн жил эхлэхээс өмнө холбогдох шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн төсөлд 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын 119 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс 17 ТАХ нь сүүлийн хоёр жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөв, төсөлтэй байх төсөвлөлтийн шаардлага хангасан байхаар боловч 6 төсөл, арга хэмжээний зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй байна. Тухайлбал:

- Орхон аймаг, Баян-Өндөр сум Кувейтийн гудамжны аюулгүйн тойргийн өргөтгөл шинэчлэлтийн авто замын барилгын ажил 68,949.3 сая төгрөг,
- 11 дүгээр хорооллын Б хэсгийн дутуу авто замыг уурхайчин хорооллын авто замтай холбох /Хүрэнбулаг баг/ 4,095.1 сая төгрөг,
- Жаргалант сумын төвд баригдах 2.5км авто замын барих 4,406.3 сая төгрөг,
- Жаргалант сумын төвд баригдах 0.7км авто зам барих ажил 1,459.0 сая төгрөг,
- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих ажил 3,281.3 сая төгрөг,
- Найрамдал багт цэцэрлэг барих ажил /280 ор/ 10,450.0 сая төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.1, 3.2.2.2, 3.2.3.4 дахь заалтад нийцээгүй байна.

Их засварын ангилалд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ихэнх ТАХ нь их засвар хийх шаардлагатай эсэхэд мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргасан эсэх нь тодорхойгүй, зайлшгүй завсарлах шаардлагатай ажлын тоо хэмжээг захиалагч тооцож баталгаажуулахгүйгээр хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.2.3-ын 3.2.3.3, 3.2.3.4-т заасан шаардлагуудыг тус тус хангаагүй байна.

Мөн тус ангилалд барилга байгууламж шинээр барих 21,249.6 сая төгрөгийн 7 ТАХ-г төлөвлөсөн байна. Үүнд:

- 2х10 МВА-р хүчдэл өргөх төхөөрөмжийн холболт хийх 4,592.7 сая төгрөг,
- 35 кВ Оюут-Булагт ЦДАШ барих 4,497.0 сая төгрөг,
- Хот доторх гэрэлтүүлэг шинээр хийх /үргэлжлэл/ 4,876.6 сая төгрөг,
- Ёслол хүндэтгэлийн өргөөний засвар, тохижилтын ажил 1,129.5 сая төгрөг,
- Том оврын авто машины нэгдсэн зогсоол хийх ажил 3,100.0 сая төгрөг,
- Согоот багийн орчны тохижилтын ажил 1,855.1 сая төгрөг,
- Уурхайчин баг. Тоглоомын талбайн тохижилтын ажил 1,198.7 сая төгрөг.

ТАХ-ний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

Их засварын ажилд төлөвлөсөн төсөл арга хэмжээнд тоног төхөөрөмжийн үнийг оруулж төлөвлөсөн байна. Тухайлбал:

¹⁶ 3.2.2.2 барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

- БОЭТ-ийн Хагалгааны ариутгалын нэгдсэн тасагт иж бүрэн вакум хагалгааны өрөө засварлах 1,400.0 сая төгрөгийн төсөв өртөгтэйгөөс 1,038.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Нутгийн удирдлагын ордны 3 давхарт өрөө гаргах,бусад тохижилтын ажил 136.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөс 21.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж.

Аймгийн төсвийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн 51 ТАХ-ний хэрэгжүүлэх болон ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах урсгал зардал, орон тоо, цалингийн зардлыг төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/ шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,075.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Найрамдал багт цэцэрлэг барих ажил /280 ор/ 10,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Их залуу баг. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих ажил 2,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Эрдэнэ баг. Спорт заал барих ажил 3,534.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Ирээдүйн одод сургуулийн спорт заал барих ажил 2,517.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Баянцагаан баг.18-р сургуулийн гал тогооны хэсгийн өргөтгөл хийх ажил 401.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Даваат баг. 17-р сургуулийн гал тогооны хэсгийн өргөтгөл хийх ажил 565.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 7 төсөл, арга хэмжээний урсгал зардал, орон тоо цалингийн зардлын тооцоог нарийвчлан хийгээгүй;
- Хот доторх гэрэлтүүлэг шинээр хийх /үргэлжлэл/ 4,876.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Эрдэнэ баг. Гудамж хоорондын гэрэлтүүлэг хийх ажил 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Дэнж баг. Кувейтийн тойргоос Экод дэлгүүр дэлгүүр хүртэлх авто замын гэрэлт гудамж болгох ажил 899.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Говил баг. Хамгаалалтын хашаа,гэрэлтүүлэг хийх ажил 547.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийт 4 төсөл, арга хэмжээний урсгал зардлын тооцоог нарийвчлан хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйл 29^{1.2.4}-т заасан шаардлагыг хангахгүй ба барилга байгууламжийн ашиглалт, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай зардлын санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байгаа нь орон нутгийн төсөвт ачаалал үүсгэх, зарим байгууламж ашиглалтад орсны дараа бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байх, хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах эрсдэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгаад царцсан сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/-ыг 2026 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьж дуусгахаар төлөвлөсөн боловч, заалтай сургуульд давхардуулан спорт заалыг 2,517.1 сая төгрөгөөр дахин шинээр барих санал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.6¹⁷-д заасантай нийцэхгүй байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан шинээр хэрэгжүүлэх 6 ТАХ-ний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилах байдлаар тооцож тусгаагүй байна. Дээрх төсөл, арга хэмжээний тухайн жилийн санхүүжилтэд ногдох 81,973.6 сая төгрөгийн санхүүжилтийг 2026 онд 18,375.30 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 70.3 хувиар бага буюу 63,598.2 сая төгрөг дутуу тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29.3.5¹⁸ дахь заалтад нийцээгүй байна. Тухайлбал:

- Орхон аймаг, Баян-Өндөр сум Кувейтийн гудамжны аюулгүйн тойргийн өргөтгөл шинэчлэлтийн авто замын барилгын ажил төсөл, арга хэмжээний 68,949.3 сая төгрөгийн төсөвт өртөгөөс тухайн жилд 68,949.3 сая төгрөгийн санхүүжилт ногдохоор байхад 2026 онд 10,000.0 сая төгрөг буюу 5.8 дахин бага;

Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх ТАХ-ээс 46 нь тоног төхөөрөмж ангилалд хамаарч байгаа ба үүнээс 8 байгууллага үнийн судалгаа, албан тоот бичиг ирүүлсэн байна. Төсвийн хөрөнгө

¹⁷ 13.1.6.улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;

¹⁸ 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

оруулалтын ТАХ-д тавих шаардлага болох ашиглалтын норм, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, төсөв, холбогдох баримт бичгийн бүрдэлт хангаагүй ТАХ-г төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх 323 ТАХ-ээс 162 нь төсөл, хөтөлбөр ангилалд хамаарч байна. Эдгээр төсөл, хөтөлбөрийн зардлын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол зэргийг нягталж, эрэмбэлдэггүй, хөгжлийн бодлоготой хэрхэн уялдсан эсэхийг тодорхойлохгүйгээр төсвийн төсөлд тусгасаар байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.16¹⁹, 4.1.17²⁰-д заасантай нийцэхгүй байна.

3.2.Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөсөөр байна.

Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн шинээр эхлэх ТАХ-үүд нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоололгүй, хөгжлийн бодлогын уялдааг хангасан эсэхийг тодорхойлохгүйгээр төсвийн төсөлд тусгасаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан байтал өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй байгууллага “ЭБЦТС ТӨХК”-нд дэмжлэг үзүүлэх 100.0 сая төгрөгийг төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашиггүй зардлыг нэмэгдүүлж байна.

Тэтгэмж, урамшуулал хавтгайруулан олгох, уралдаан тэмцээн, баяр наадам, зохион байгуулах зардалд төсөл, хөтөлбөрөөс 3 ТАХ-нд 390.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3²¹ дах заалттай нийцэхгүй, үр ашиггүй зардал байна. Тухайлбал:

- Баян-Өндөр уул болон Тэнгэрийн 7 бурхан одны тахилгын зардал 40.0 сая төгрөг,
- Тэгш ой тэмдэглэх байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зардал 200.0 сая төгрөг,
- Аймгийн хэмжээнд зохион байгуулагддаг тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах үйл ажиллагааны зардал (“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол цэргийн өдөр”, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол бахархлын өдөр”, “Улс тунхагласны баяр”, “Эрдэнэт хотын болон Анхдагч илгээлтийн эздийн өдөр”, аймгийн хэмжээнд шинэ он угтах үйл ажиллагааг зохион байгуулах) 150.0 сая төгрөг.

Төсвийн байгууллагын орон тоог батлагдсан орон тооны хязгаарт багтаан тооцолгүй төсөл хөтөлбөрийн зардлаас 289.3 сая төгрөгийн цалинг олгохоор төлөвлөсөн нь Төсвийн

¹⁹ Төсвийн тухай хуулийн 4.1.16-д “хөтөлбөр - гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг”;

²⁰ Төсвийн тухай хуулийн 4.1.17-д “арга хэмжээ - гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг”

²¹ 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

тухай хуулийн 14.2.12²² дах заалттай нийцэхгүй, үр ашиггүй зардлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал:

- Хамтын ажиллагаа, гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн удирдагчийн зардал 77.3 сая төгрөг,
- Угтах үйлчилгээний зардал /Хөтөч/ 30.0 сая төгрөг,
- Туслах сувилагч ажиллуулах зардал /12 хүн/ 78.0 сая төгрөг,
- Америк соёл мэдээллийн төвийн багш нарын цалин, НДШ-ийн зардал 104.0 сая төгрөг.

Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй босоо тогтолцоотой газрын тохижилт, урсгал засварын зардлыг төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхээр 1,677.2 сая төгрөгийг төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6.4.2²³ дах заалттай нийцэхгүй, үр ашиггүй, зориулалт бус зарцуулалтыг нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал:

- Зэвсэгт хүчний 186-р ангийн талбайн тохижилт хийх ажил 800.0 сая төгрөг,
- Татварын газрын 110 тоот өрөөний засварын ажил 30.2 сая төгрөг,
- Цагдаагийн газрын байранд засвар, тохижилт хийх ажил 401.1 сая төгрөг,
- Авто тээврийн төвийн албан хаагчдад энгэрийн камер худалдан авах 35.0 сая төгрөг,
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 43.8 сая төгрөг.
- Хүүхдийн асрамжийн “Энэрэл” төвд тоног төхөөрөмж худалдан авах 19.9 сая төгрөг.

Зөвлөл, комисс, хорооны гишүүдэд 441.8 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олгохоор төсөл, хөтөлбөрийн зардалд төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2²⁴ дах заалттай нийцэхгүй, үргүй зардлыг өсгөж байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн магадлан зөвлөлийн комисст шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах 25.8 сая төгрөг,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд тоног төхөөрөмж худалдан авах 163.6 сая төгрөг,
- Монгол хэлний бодлогын салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал 10.0 сая төгрөг,
- Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны зардал 20.0 сая төгрөг,
- Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардал 20.0 сая төгрөг,
- Нийгмийн халамжийн зөвлөлийн шийдвэр хэрэгжүүлэх зардал 50.0 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлд дэмжлэг үзүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын зардал 50.0 сая төгрөг,
- Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагааны зардал 15.0 сая төгрөг,
- Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал 15.0 сая төгрөг,
- Аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал 72.4 сая төгрөг.

“Нийтлэг үйлчилгээний алба” төрийн байгууллагын албан хэрэгцээнд авто машин худалдан авахад 65.0 сая төгрөг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2²⁵ дах заалттай нийцэхгүй, үр ашиггүй зардлыг өсгөхөөр байна.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛСАН БАЙНА.

1. Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хууль, Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн

²² 14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.

²³ 6.4.2.төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

²⁴ 10.2.Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.

²⁵ 6.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

2. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

3. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар аймгийн Засаг даргад 2 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орхон аймгийн 2026 оны төсвийн төсөл нь дунд хугацааны бодлогын баримтын бичгүүдтэй 95.4 хувь нийцсэн байна.
- Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орлогыг 1,921.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн зарлагыг 5,157.7 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.
- Аймгийн 2026 оны төсвийн татварын орлогыг 605.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,316.0 сая төгрөгөөр нийт 1,921.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны төсвийн төсөл 4,081.1 сая төгрөгийн зардлаас 1,255.0 сая төгрөгийн 5 арга хэмжээг бууруулах саналтай байна.
- Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд төсөвлөлтийн шаардлага хангаагүй 14 ТАХ-г тусгасан байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, урсгал зардлын тооцоолол, судалгаагүй төлөвлөсөөр байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Засаг даргад:

- Барилга байгууламжийн 6 төсөл, арга хэмжээний зураг төсөвт 2025 оны 12 сарын 25-ны дотор магадлал хийлгэх.
- Шинээр хэрэгжих 14 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсвийн жил эхлэхээс өмнө боловсруулах.

ХАВСРАЛТ:

Аймгийн төсвөөс 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөвгүй тусгасан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгын нэгдсэн бохирын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх / НҮБ-тай хамтран хэрэгжүүлэх/	2025	2026	70,000.00	70,000.00	
2	Кувейтийн аюулгүйн тойргоос-Эрх чөлөөний өргөн чөлөөний авто замын уулзвар-Ханддорж, Улаан-Үдийн гудамжны уулзвар хүртэл авто замд засвар шинэчлэлтийн ажил	2026	2026	573,459.32	573,459.32	
3	Баянцагаан багийн нутаг улсын чанартай А1001 дугаартай Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замд авто тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах ажил	2026	2026	143,401.27	143,401.27	
4	Их Залуу баг. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих ажил	2026	2027	2,800,000.00	900,000.00	Зурагтай, төсөвгүй
5	Суурин газрын хөрсийг хамгаалах зорилгоор мод тарих	2026	2026	30,000.0	30,000.0	
6	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Баян-өндөр сумын гэр хороололд шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламжийн суурийн хэсгийг бариулах ажил	2026	2026	200,000.0	200,000.0	
7	Уул уурхайн бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажил	2026	2026	25,000.0	25,000.0	
8	Дотоодын цэргийн 821-р ангийн хяналтын цэгүүдийг шилэн кабельд холбох ажил	2026	2026	248,140.00	248,140.00	
9	Бүрэнбүст баг. Залуус хотхоны авто зогсоол шинэчлэх ажил	2026	2026	328,639.50	328,639.50	
10	Бүрэнбүст баг.Орон сууцны 5-12-р байр 5-13-р байрыг холбосон авто замын ажил	2026	2026	119,839.30	119,839.30	
11	Дэнж баг. Кувейтийн тойргоос Экод дэлгүүр хүртэлх авто замын гэрэлт гудамж болгох ажил	2026	2026	899,664.44	899,664.44	
12	Хүрэн булаг. Орон сууцны 4-р хорооллын 5-р байрны авто зогсоол засварлах ажил	2026	2026	265,750.03	265,750.03	
13	Хүрэнбулаг баг. Дагинас төвөөс ӨЭМТ-ийн авто зогсоол хүртэлх авто зам барих ажил	2026	2026	143,003.02	143,003.02	
14	МХС байрны гадна зогсоол хийх ажил	2026	2026	151,974.20	151,974.20	
	НИЙТ			5,998,871.08	4,098,871.08	